



Зөвлөмжийн Цуврал

ЗЦ92-2

Нэмэлт, өөрчлөлт 1 (1)

Орон нутгийн VFR-аар үйлдэх нислэгт

МСТOW нь 5700 кг-аас ихгүй, битүүмжлэлгүй агаарын хөлгөөр

Аюултай бараа тээвэрлэх

2021 оны 6 сарын 8

Ерөнхий

Иргэний нисэхийн ерөнхий газрын Зөвлөмжийн цуврал (ЗЦ) нь холбогдох дүрмийн шаардлагыг хангаж байгааг Дарга хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр илэрхийлсэн стандарт, туршлага, журмуудыг агуулсан байдаг.

Хүлээн зөвшөөрөхүйц хэлбэр нь Даргад дүрмийн шаардлагыг хангаж байгааг нотлох цорын ганц хэлбэр биш юм. Хүлээн зөвшөөрөхүйц шинэ стандарт, туршлага, эсхүл журам гарч ирсэн тохиолдолд холбогдох ЗЦ-д нэмж оруулах болно.

Түүнчлэн, энэхүү ЗЦ нь дүрмийн шаардлагыг хангах зааварчилгаа материалыг агуулсан болно. Зааварчилгаа материал нь хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрт тооцогдохгүй.

Зорилго

Энэхүү ЗЦ нь ИНД-92-д заасан дүрэмд хамааралгүйгээр, орон нутгийн VFR-аар үйлдэх нислэгт МСТOW нь 5700 кг ихгүй, битүүмжлэлгүй агаарын хөлгөөр Аюултай бараа тээвэрлэх аргачлалыг агуулсан болно.

Хамааралтай дүрмүүд

Энэхүү ЗЦ нь ИНД-92, ИНД-92.11(с)-т шууд хамаарна.

Өөрчлөлтийн тэмдэглэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг боловсруулсан.

ЗЦ92-2-ыг монгол болон англи хэл дээр боловсруулсан бөгөөд хэрэв эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хэл дээрх хувилбарыг баримтална.

ЗЦ92-2-ыг NZ AC92-2-ын 2007 оны 04 сарын 27-ны өөрчлөлт 1-д үндэслэн боловсруулсан болно.

Өмнөх үг

Агаараар тээвэрлэх зарим аюултай бараа нь ИНД-92-ийн шаардлагад үл хамаарна. МСТOW нь 5700 кг, эсхүл түүнээс доош жинтэй, битүүмжлэлгүй агаарын хөлгөөр VFR-аар зарим эд зүйлийг тээвэрлэж болдог. VFR-аар нислэг үйлдэх агаарын тээвэрлэгч аюултай барааг агаараар тээвэрлэхдээ бусад агаарын тээвэрлэгчдэд тавигддаг олон тооны шаардлагыг дагаж мөрдөх шаардлагагүй юм.

Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь хөлс, эсхүл шан урамшуулалттай, эсхүл хувийн нислэг үйлдэж байгаагаас үл хамааран аюултай барааг агаараар аюулгүй тээвэрлэх шаардлагын талаар мэдэж байх нь чухал.

VFR-аар нислэг үйлддэг олон агаарын хөлгүүд бусад төрлийн тээврийн хэрэгсэл хүрэх боломжгүй бүс нутаг руу нислэг үйлддэг. Эдгээр газар руу тээвэрлэгдэж байгаа аюултай бараа нь ихэвчлэн зорчигчдын аялал, спортын хэрэгцээний эд зүйл байдаг. Өөр нэг жишээ бол анчид, загасчдын отогт хүргэж байгаа хангалтын эд зүйл юм.

Эдгээр эд зүйлийг тээвэрлэдэг агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч холбогдох дүрэм болон шаардлагыг хэрхэн биелүүлэх талаар ойлголттой байх нь агаарын хөлгийн аюулгүй байдал болон түүнд зорчиж байгаа хүмүүсийг эрсдэлд оруулахаас сэргийлнэ.

Тээвэрлэгч нь аюултай барааг агаараар аюулгүй тээвэрлэх аргачлал, журмыг доор дурдсан байна.

Гарчиг

| | |
|--|---|
| Өмнөх үг | 2 |
| 1. Аюултай бараа гэж юу вэ..... | 4 |
| 2. Агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглосон Аюултай бараа | 4 |
| 3. Аюултай барааг таних..... | 4 |
| 4. Аюултай барааг тусгаарлах..... | 5 |
| 5. Тохиромжтой нөхцөл..... | 6 |
| 6. Аюултай барааг аюулгүй бэхлэх болон баглаа боодол | 7 |
| 7. Аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга хэмжээ | 7 |
| 8. Онцгой нөхцөлийн журам | 7 |

1. Аюултай бараа гэж юу вэ

Аюултай бараа гэж эрүүл мэнд, аюулгүй байдал, өмч хөрөнгө, эсхүл хүрээлэн буй орчинд эрсдэл учруулж болох дараах эд зүйл, эсхүл бодисыг:

- 1) ICAO-ын Аюултай барааг агаараар тээвэрлэх Техникийн Зааварчилгаанд заагдсан, эсхүл ангилагдсан; эсхүл
- 2) ICAO-ын Аюултай барааг агаараар аюулгүй тээвэрлэх Техникийн Зааварчилгааны дагуу аюултай бараа гэж ангилагдсан эд зүйл, эсхүл бодисын хэв шинжийг агуулсан.

Хамгийн түгээмэл аюултай бараа бол түлш юм. Та бүхний ихэнх нь түлштэй харьцаж байхдаа эцэг эхчүүдээсээ аюулгүй байдлын анхааруулга сонсож байсан байх, тухайлбал түлш нь шатамхай, ойр хавьд нь тамхи татахгүй, ил гал гаргахгүй, сайтар тагласан тохирох саванд хадгалах, ууршсан үедээ аюултай гэх мэт.

Ахуйн, эсхүл засварын газрын, үйлдвэрлэлийн төрөл бүрийн химийн бодис, эсхүл нэгдлүүд нь агаарын хөлгөөр тээвэрлэгдэх үедээ хүмүүст илүү их аюул учруулах магадлалтай.

2. Агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглосон аюултай бараа

Ачааны аюултай шинж чанараас шалтгаалан зарим эд зүйлийг агаарын хөлгөөр тээвэрлэх хориотой ба заримыг нь зөвхөн ачааны агаарын хөлгөөр тээвэрлэх боломжтой болохыг мэдэж байх нь зүйтэй. Тэсрэх бодис, эсхүл тэслэх төхөөрөмж нь илэрхий жишээ юм. Гэвч нислэгийн хэвийн нөхцөлийн үед халалт болон хий үүсгэж болзошгүй хэд хэдэн зүйл байдаг. Тэдгээрийг ямар ч нөхцөлд агаараар тээвэрлэхгүй байх ёстой.

3. Аюултай барааг таних

Энэ заалтыг үйл ажиллагаандаа мөрдөх агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь зорчигчийн аялал зугаалга, спортын зориулалттай эд зүйлийг тээвэрлэх дадлага туршлагатай байх нь зүйтэй. Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь тээвэрлэлтэд хүлээн авах эдгээр эд зүйлийг таньж тодорхойлон нисгэгчийг зохих мэдээллээр хангаснаар нисгэгч ямар эд зүйлийг тээвэрлэх талаар хувийн шийдвэр гаргахгүй байх давуу талтай.

Дараах эд зүйл нь агаараар түгээмэл тээвэрлэгддэг:

- a) Аяллын зориулалттай дахин цэнэглэдэг, эсхүл хаягдал хийн баллон
- b) Аяны, эсхүл спортын зориулалттай бага хэмжээний тэсрэх бодис
- c) Халаагч, зуух, гэрлийн чийдэн ажиллуулахад шаардлагатай түлш, керосин, эсхүл бусад шатамхай шингэн
- d) Хатуу түлшийг шатаагч болон хатуу түлш, халаагч гэх мэт
- e) Усанд шумбагчийн хийн баллон, хоосон, эсхүл дүүрэн

- f) Цахилгаан үүсгүүр ажиллуулах зориулалттай зай хураагуур, эрчим хүчний нөөц эх үүсвэр гэх мэт.

Хэрэв танд аливаа эд зүйл болон бодис нь аюултай бараа гэж санагдаж байвал тэдгээрийг тээвэрлэхгүй байх, эсхүл энэ талаар зөвлөгөө авах хэрэгтэй.

4. Аюултай барааг тусгаарлах

Зарим эд зүйл болон бодис нь хоорондоо урвалд орж хортой хий үүсгэх, гал авалцах зэргээр аюултай нөхцөл байдал үүсгэдэг. Иймд эдгээр бодисуудыг тусгаарлаж, хоорондоо урвалд орохоос сэргийлэх нь зүйтэй.

Энгийн ачааг хооронд нь байрлуулж тусгаарлах, эсхүл агаарын хөлгийн ачааны өөр өөр тасалгаанд байрлуулах зэргээр тусгаарлаж болно.

ICAO-гийн Техникийн зааварчилгаанд тусгаарлах шаардлагатай бодисуудыг ангилал, эсхүл бүлгээр нь заасан бүрэн жагсаалт агуулагдсан. Тээвэрлэхийг дүрмээр хориглосон боловч тээвэрлэгдэж магадгүй эд зүйлийг доорх хүснэгтэд багтаасан байна. Энэхүү хүснэгтэд багтаагүй бодисын талаарх зөвлөгөөг ICAO-гийн Техникийн зааварчилгааны мэдлэгтэй хүнээс авах нь зүйтэй.

| Ангилал, эсхүл бүлэг | Тусгаарлавал зохих ангилал, эсхүл бүлэг |
|---|---|
| Ангилал 1 – Тэсрэмтгий бодис | Ангилал 8 - Идэмхий бодис |
| Ангилал 3 – Шатамхай шингэн | Бүлэг 5.1 – Исэлдэгч бодис Бүлэг 5.2 – Органик хэт исэл |
| Бүлэг 4.2 - Тээвэрлэлтийн явцад өөрөө өдөөгдөж болзошгүй шатамхай хатуу биет | Бүлэг 5.1 - Исэлдэгч бодис Бүлэг 5.2 – Органик хэт исэл Ангилал 8 - Идэмхий бодис |
| Бүлэг 4.3 – Устай урвалд орсон үед шатамхай хий ялгаруулдаг шатамхай хатуу биет | Бүлэг 5.1 - Исэлдэгч бодис Бүлэг 5.2 – Органик хэт исэл Ангилал 8 – Идэмхий бодис |
| Бүлэг 5.1 – Исэлдэгч бодис | Ангилал 3 – Шатамхай шингэн Бүлэг 4.2 – Тээвэрлэлтийн явцад өөрөө өдөөгдөж болзошгүй шатамхай хатуу биет Бүлэг 4.3 - Устай урвалд орсон үед шатамхай хий ялгаруулдаг шатамхай хатуу биет Ангилал 8 – Идэмхий бодис |
| Бүлэг 5.2 - Органик хэт исэл | Ангилал 3 – Шатамхай шингэн Бүлэг 4.2 – Тээвэрлэлтийн явцад өөрөө өдөөгдөж болзошгүй шатамхай хатуу биет |

| | |
|---------------------------|---|
| | Бүлэг 4.3 - Устай урвалд орсон үед шатамхай хий ялгаруулдаг шатамхай хатуу биет Ангилал 8 – Идэмхий бодис |
| Ангилал 8 – Идэмхий бодис | Ангилал 1 – Тэсрэмтгий бодис Бүлэг 4.2 – Тээвэрлэлтийн явцад өөрөө өдөөгдөж болзошгүй шатамхай хатуу биет Бүлэг 4.3 - Устай урвалд орсон үед шатамхай хий ялгаруулдаг шатамхай хатуу биет Бүлэг 5.1 - Исэлдэгч бодис Бүлэг 5.2 – Органик хэт исэл |

Жагсаалтад байгаа эд зүйл болон бодисыг таньж мэдэхэд амархан байдаг боловч зарим нь үгүй байдаг. Ангилал, эсхүл бүлэг болгоны жишээг доор дурдав.

| Ангилал, эсхүл бүлэг | Жишээ |
|---|---|
| Тэсрэх бодис | Тэсрэх бодис бүхий сумны хонгио |
| Идэмхий бодис | Зайн хүчил, меркурий |
| Шатамхай шингэн | Түлш, керосин |
| Шатамхай биет | Шүдэнз, улаан фосфор, магнийн ялтас, кино хальс, камфор |
| Исэлдэгч бодис | Усан сангийн хлор, хэт исэл |
| Өөрөө өдөөгдөж болзошгүй шатамхай хатуу биет | Цагаан, шар фосфор, хүхэр |
| Устай урвалд орсон үед шатамхай хий ялгаруулдаг бодис | Кальцийн карбид, нунтаг хөнгөн цагаан, эсхүл төмөр, төмрийн натри |

5. Тохиромжтой нөхцөл

Энэ дүрмийн шаардлагын дагуу эд зүйлийг тээвэрлэх тээвэрлэгч бүр нь баглаа боодол болон контейнер эвдэрч гэмтсэн, асгарч гоожсон эсэхийг шалгах нь зүйтэй. Метал контейнер зэвэрсэн шинж тэмдэггүй байх нь зүйтэй. Хийн баллон, усанд шумбалтын

баллоныг туршсан хугацаа болон хүчинтэй хугацааг шалгаж, контейнерын таг болон хавхлагыг мөн аюулгүй байдлын үүднээс шалгана. Тэсрэх бодис бүхий баглаа боодол нь тэсрэх бодисыг унах, хөдлөх нөхцөлд хүргэхгүй байхуйц бүрэн бүтэн байна.

6. Аюултай барааг аюулгүй бэхлэх болон баглаа боодол

ИКАО-гийн баглаа боодлын шаардлага нь энэ дүрэмд хамаарахгүй боловч бүх эд зүйл болон бодисыг тэдгээрт тусгайлан зориулсан контейнер, савлалтанд тээвэрлэх нь зүйтэй. Жишээ нь түлшийг зөвхөн түлш агуулахад зориулсан тусгай контейнерт тээвэрлэнэ. Шил, эсхүл хуванцар бортогоно тохиромжгүй. Тэсрэх бодисыг мөн тусгайлан зориулсан контейнерт тээвэрлэнэ. Нийлэг уут, эсхүл баглаа боодлын хажуугийн тасалгаанд хөдөлгөөнтэй байхаар сулхан хийсэн тэсрэх бодис аюултай.

Хэвийн нислэгийн үед контейнерыг гэмтээх эрсдлийг багасгах зорилгоор бүх эд зүйлийн аюулгүй байдлыг хангаж, хөдөлгөөнгүй бэхэлсэн байх нь зүйтэй. Ачаалахын өмнө хийн бортогыг зуух, дэнлүү, ноцоогч зэргээс тусад нь байрлуулах ба тохируулагч, гуурсан хоолойг салгана.

Усанд шумбалтын бортогоны гуурс, тохируулагчийг салгана. Шатамхай хий бүхий нэг ширхэг хийн бортого, эсхүл бага хэмжээтэй аюултай барааг цүнх, үүргэвчинд хийж хувцас зэргээр ороож болно. Илүү их хэмжээтэй аюултай барааны хувьд тусад нь контейнерт хийж, агаарын хөлөгт хөдөлгөөнгүй байхаар бэхэлж байрлуулна.

7. Аюулгүй байдлын урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Тээвэрлэж байгаа аюултай бараа болон хэрэв хамааралтай бол, тэдгээрийн аюултай шинж чанар, нислэгийн үед тэдгээрээс сэргийлэх арга хэмжээний талаар зорчигчдод мэдээлэл өгөх нь зүйтэй. Үүнд:

- шатамхай бодис ойр байх үед агаарын хөлөгт, эсхүл агаарын хөлгийн ойролцоо тамхи татахыг хориглох,
- зорчигчийг суулгах, буулгах, ачаа тээшийг ачаалах буулгах үед анхаарал болгоомжтой ажиллах.

8. Онцгой нөхцөлийн журам

Энэ дүрмийн дагуу аюултай барааг тээвэрлэдэг агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч бүр нь тэдгээр аюултай барааг агаарын хөлгөөр тээвэрлэж болох эсэхийг таньж мэдэх нь зүйтэй. Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь нислэгийн үед аюултай бараатай холбоотой гарсан онцгой нөхцөлд авах журмын талаарх мэдээллээр нисгэгчийг хангана.

Агаарын хөлгийн бүхээгт утаа гарах үед дараах арга хэмжээг авч ажиллана:

- нэн даруй газардах
- хэрвээ заагдсан бол агаарын хөлгийн нислэгийн зааварт заасан утаа арилгах онцгой нөхцөлийн журмыг дагах

- бүхээгийн агаарын бохирдлыг багасгах, агаарын солилцоог хангах үүднээс агаар солилцооны системийг дээд хүчин чадлаар ажиллуулах

ICAO Doc 9481-AN/928 “Агаарын хөлөгт аюултай бараатай холбоотой осол зөрчил гарах үед ажиллах журам”-д нэмэлт мэдээллүүд агуулагдсан байгаа. Агаарын тээвэрлэгч өөрийн тээвэрлэж байгаа аюултай барааны ангилалд тохирох журмыг тусгайлан ашиглаж болно.

Жишээлбэл аялагчдад зориулсан LPG хийн цилиндрийг тээвэрлэх агаарын тээвэрлэгч тээвэрлэх бол UN2037 “Хий бүхий бага оврын сав”-д хамаарах 10L кодыг мөрдөнө.